


# 2020 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК



# Агуулга

<b>01</b>	Зээлийн үйл ажиллагаа	04
<b>02</b>	Бизнесийн үйл ажиллагаа	07
<b>03</b>	Санхүүгийн үйл ажиллагаа	11
<b>04</b>	Эрсдэлийн удирдлага	14
<b>05</b>	Харилцагчийн үйлчилгээ	17
<b>06</b>	Компанийн засаглал	20





## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

# “ О.Болдбаатар: “ЛэндМН ББСБ” ХК зээлийн шинэ бүтээгдэхүүнээ танилцууллаа ”



О.БОЛДБААТАР (Гүйцэтгэх захирал)

Сайн байна уу? Эрхэм хүндэт харилцагчид, хөрөнгө оруулагчид, хамтрагч байгууллагууд та бүхэндээ 2020 оны 3-р улирлын санхүү, үйл ажиллагааныхаа тайланг хүргэж байна.

COVID-19 халдварт өвчнөөс үүдэлтэй эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилж байгаа хэдий ч бид харилцагчдынхаа бизнесийн болон санхүүгийн нөхцөл байдалд тохируулан боломжит бүх хэлбэрээр дэмжин хамтдаа даван туулахаар ажиллаж байна.

Бид энэ улиралд зээлийн шинэ бүтээгдэхүүнээ зах зээлд амжилттай нэвтрүүлээ. Олон улсад өргөн хэрэглэгддэг худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг нэвтрүүлж хэрэглэгчдэдээ хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр шууд аваад, төлбөрөө 30 хоногийн хугацаанд ямар ч хүү, шимтгэлгүйгээр эргэн төлөх таатай нөхцөлийг олгож байна.

Хэрэглэгчид маань LendMN аппликейшнээр дамжуулан хиймэл оюун ухаан дээр суурилсан хэрэглээний цахим зээлийн үйлчилгээг авдаг бол энэхүү худалдан авалтын зээлийн үйлчилгээг SuperUp

аппликейшнээр дамжуулан авах боломжтой. LendMN аппликейшний хэрэглэгчид маань SuperUp аппликейшнд өөрийн бүртгэлээрээ шууд нэвтрэх боломжтой бөгөөд өнөөдрийн байдлаар 25.000 гаруй харилцагчид энэ бүтээгдэхүүнийг авах эрх нээгдээд байна.

Үүнээс гадна “ЛэндМН ББСБ” ХК төлбөр тооцоо, цахим хэтэвчийн үйлчилгээгээ өөрийн охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-д албан ёсоор шилжүүлж технологид суурилсан санхүүгийн шийдлийг хүн бүрд хүртээмжтэй, хялбар, аюулгүй, найдвартай байдлаар хүргэх, төлбөр тооцооны цогц дижитал экосистемийг бүрдүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

2020 оны 3 дугаар улирал бидний хувьд шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд танилцуулсан амжилттай улирлынхаа санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна. Үргэлж биднийг дэмждэг та бүхний ажил үйлс өөдөө байж, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе!

**Хүндэтгэсэн**“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал  
О.Болдбаатар

2020.10.15



01

# Зээлийн үйл ажиллагаа

## Зээлийн үйл ажиллагаа

2020 оны III улиралд нийт хэрэглэгчдэдээ 36.5 тэрбум төгрөгийн 172.4 мянган зээлийг LendMN аппликэйшнээр дамжуулан олгосон байна. 2020 оны III улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2020 оны II улиралтай харьцуулахад олгосон зээлийн тоо 2.3 дахин өссөн, олгосон зээлийн үнийн дүн 2.1 дахин өссөн, зээлийн багц 4.5%-иар буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны эхний 3-н улиралын нийт олгосон зээлийн үнийн дүн 176.9 тэрбум төгрөгт хүрсэн. COVID-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн 2020 оны I болон II дугаар улиралд зээл олголтыг багасгаж хэрэглэгчдийг дахин скоринг хийж эхэлсэн байсан бол 2020 оны III дугаар улиралд бүх хэрэглэгчдээ дахин скоринг хийж дууссан ба зээл олголтыг үе шаттайгаар буцаан сэргээж байна. Үүний үр дүнд зээлийн багцын хэмжээ тогтворжиж эхэлсэн ба 2020 оны IV дүгээр улиралд үргэлжлүүлэн зээл олголтоо нэмэгдүүлэх болон шинээр нэвтрүүлсэн SupPAY зээлийн бүтээгдэхүүний цар хүрээг улам нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

### 2020 оны III улирлын тайлангийн үзүүлэлтүүдийг I, II улирлын тайлант үетэй харьцуулсан байдал



## Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2020 оны III улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хувь 6.9% болон өсч, эрсдэлийн сангийн хүрэлцээ 96% болсон үзүүлэлттэй байна. COVID-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн 2020 оны I болон II дугаар улиралд орлого багассан харилцагчдын зээл 2020 оны III дугаар улиралд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилал руу шилжиж байгаа тул III дугаар улиралд 600 сая төгрөгийн нэмэлт эрсдэлийн сан байгуулж эрсдэлийн сангийн хүрэлцээг 96%-д хүргэлээ.

Мөн орлого багассан болон хугацаа хэтрэлтэд орсон харилцагчдадаа зээлийн хугацааг сунгах, шимтгэл болон үндсэн төлбөрөөс тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг түлхүү авч хэрэгжүүлж байна.

Тэрбум төгрөг	2020 он I улирал	2020 он II улирал	2020 он III улирал
<b>Нийт зээлийн багц</b>	<b>52.5</b>	<b>33.9</b>	<b>32.3</b>
Зээлийн эрсдэлийн сан	(2.1)	(1.5)	(2.1)
<b>Цэвэр зээлийн багц</b>	<b>50.4</b>	<b>32.4</b>	<b>30.2</b>
Хэвийн зээл	50.3	31.5	28.9
Хугацаа хэтэрсэн зээл	0.6	0.6	1.2
Чанаргүй зээл	1.6	1.7	2.2
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	3.0%	5.1%	6.9%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	131.3%	88.4%	96%

02

# Бизнесийн үйл ажиллагаа



## Бизнесийн үйл ажиллагаа

# "ЛэндМН ББСБ" ХК нь цахим хэтэвч болон төлбөрийн үйлчилгээгээ Монгол банкны тусгай зөвшөөрөл эзэмшигч "Супер Ап Хэтэвч" ХХК-д шилжүүллээ.


“ЛэндМН ББСБ” ХК нь харилцагчдадаа цахим төлбөр тооцооны үйлчилгээг хүргэхээр “Үндэсний төлбөрийн системийн тухай” хууль болон “Монголбанкны цахим мөнгөний журам”-ын дагуу “Супер Ап Хэтэвч” ХХК-г үүсгэн байгуулсан.

“Супер Ап Хэтэвч” ХХК нь 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А-174 тоот тушаалаар Монголбанкнаас “Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” гардан авч, цахим мөнгөний зөвшөөрөлтэй 2 дахь байгууллага болсон бөгөөд энэхүү зөвшөөрөлтэй холбогдуулан 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс эхлэн “ЛэндМН ББСБ” ХК цахим хэтэвч, төлбөр тооцооны үйлчилгээгээ “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүллээ.

“Супер Ап Хэтэвч” ХХК нь LendMN болон SuperUp

аппликейшнуудаар дамжуулан технологид суурилсан санхүүгийн шийдлийг хүн бүрд хүртээмжтэй, хялбар, аюулгүй, найдвартай байдлаар хүргэх, төлбөр тооцооны цогц дижитал экосистемийг бүрдүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

Цахим төлбөр тооцооны хэтэвчийг ашигласнаар өдөр тутмын төлбөр тооцооноос гадна бүх төрлийн хүргэлт, онлайн шоп, энтермейнмент үйлчилгээ, хөнгөлөлт урамшууллыг ердөө нэг цахим хэтэвчээр дамжуулан төлбөрийн системийн оролцогч бусад байгууллагуудтай хамтран төлбөр тооцооны хялбар шийдэл, нэмэлт боломжуудыг хөгжүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэх боломжтой боллоо.






# SupPAY


## Худалдан авалтын зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргалаа

“ЛэндМН ББСБ” ХК олон улсад өргөн хэрэглэгддэг санхүүгийн бүтээгдэхүүн болох худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг нэвтрүүлээ. Бид энэхүү үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдэдээ хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр шууд аваад, төлбөрөө 30 хоногийн хугацаанд ямар ч хүү, шимтгэл гэх нэмэлт төлбөргүйгээр эргэн төлөх таатай нөхцөлийг олгож байна.



SupPAY -р шууд авах боломжтой АВАХ

HAYLOU  
Xiaomi Haylou LS05-1 Solar Smart watch  
189,000 ₮  
Тоо ширхэг  
ШУУД АВАХ САГСАНД НЭМЭХ





Та LendMN аппликейшнээр дамжуулан хиймэл оюун ухаан дээр суурилсан хэрэглээний цахим зээлийн үйлчилгээг авдаг бол, худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг SuperUp аппликейшнээр дамжуулан авах юм. SuperUp аппликейшний Банана онлайн дэлгүүрийн SupPAY тэмдэглэгээтэй 10,000 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс өөрийн сонголтоо хийгээд л шууд авах боломжтой.

LendMN аппликейшний хэрэглэгчид SuperUp аппликейшнд өөрийн бүртгэлээрээ шууд нэвтрэх

боломжтой бөгөөд SupPAY зээлийн эрхээ тооцуулснаар та хүссэн бүхнээ, хүссэн үедээ гар утаснаасаа захиалаад л хүссэн газраа шууд авах боломжтой боллоо.

Бид SupPAY үйлчилгээний нөхцөлийг улам сайжруулж, харилцагчдын хэрэглээнд суурилсан, худалдан авалтын зээлийн хугацааны хувьд хамгийн тохиромжтой, боловсронгуй хувилбаруудыг шинэчлэн нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



**2 САЯ ₮**  
ХҮРТЭЛХ БАРААГ  
**ШУУД АВ**

TECH & GADGETS



УРЬДЧИЛГААГҮЙ  
**ШУУД АВ.**



03

# Санхүүгийн үйл ажиллагаа



## Санхүүгийн байдлын хураангуй тайлан /аудитлагдаагүй/

2020 оны III улирлын байдлаар компанийн нийт хөрөнгө 42.4 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 30.2 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 5.7 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 23.4 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 19 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 8.5 тэрбум төгрөг байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2020 он I улирал	2020 он II улирал	2020 он III улирал
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6.6	9.6	5.7
Зээлийн багц (цэврээр)	50.4	32.3	30.2
Бусад хөрөнгө	4.1	3.7	5.2
Үндсэн хөрөнгө	1.3	1.2	1.1
Биет бус хөрөнгө	0.2	0.2	0.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>62.6</b>	<b>47.1</b>	<b>42.4</b>

Өр төлбөр болон эздийн өмч /Тэрбум төгрөг/	2020 он I улирал	2020 он II улирал	2020 он III улирал
<b>Өр төлбөр</b>	<b>44.9</b>	<b>28.3</b>	<b>23.4</b>
Эх үүсвэр	40.5	25.7	21.5
Бусад өр төлбөр	4.4	2.6	1.9
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17.7</b>	<b>18.8</b>	<b>19</b>
Хувьцаат капитал	10.5	10.5	10.5
Хуримтлагдсан ашиг	7.2	8.3	8.5
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>62.6</b>	<b>47.1</b>	<b>42.4</b>




## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Өссөн дүнгээр/


2020 оны эхний 3-н улирлын байдлаар нийт орлогын хэмжээ 13.1 тэрбум төгрөг байгаагаас 3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2020 он I улирал	2020 он II улирал	2020 он III улирал
Нийт орлого	6	9.8	13.1
Хүүгийн зардал	(1.9)	(3.3)	(4.3)
<b>Санхүүгийн цэвэр орлого</b>	<b>4.1</b>	<b>6.5</b>	<b>8.8</b>
Банк болон бусад шимтгэл	(0.5)	(0.9)	(1.3)
<b>Шимтгэлийн дараах орлого</b>	<b>3.6</b>	<b>5.6</b>	<b>7.5</b>
Эрсдэлийн сангийн зардал	(0.5)	(0.2)	(0.8)
<b>Эрсдэлийн сангийн дараах орлого</b>	<b>3.1</b>	<b>5.4</b>	<b>6.7</b>
Боловсон хүчний зардал	(0.6)	(1.1)	(1.6)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.6)	(1.2)	(1.8)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1.9</b>	<b>3.2</b>	<b>3.4</b>
Татварын зардал	(0.2)	(0.37)	(0.39)
<b>Цэвэр ашиг</b>	<b>1.7</b>	<b>2.8</b>	<b>3.0</b>

Орлого, өссөн дүнгээр  
(Тэрбум төгрөг)



Цэвэр ашиг, өссөн дүнгээр  
(Тэрбум төгрөг)



# 04

## Эрсдэлийн удирдлага

## Эрсдэлийн удирдлага

“ЛэндМН ББСБ” ХК нь эрсдэлийн удирдлагын сайн засаглал болон эрсдэлийн менежментийн үр дүнтэй болгох нэгдсэн тогтолцоог бий болгон ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээ, төрлийг тодорхойлон “ЛэндМН ББСБ” ХК-ийн

бизнесийн стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн тогтоон улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороонд гүйцэтгэлийг тайлагнан ажиллаж байна. Энэ нь эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, эдийн засаг, зохицуулалтын орчин, өрсөлдөөн дэх хөгжил, хариу үйлдэл, өөрчлөлтөд бэлэн байх зэрэг төлөвлөгөөг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын

баримт бичгийг баталж, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн тогтолцоо, цар хүрээ, зээлийн багц, эрсдэлийн хяналт зохистой

түвшинд, үр дүнтэй байгаа эсэх талаар тайланг улирал бүр хэлэлцэн дүгнэдэг. 2020 оны 3-р улирлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 3-р улиралд бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

2020 оны 2-р улиралд цар тахлаас үүдэлтэй санхүүгийн хямралтай холбоотойгоор зээлийн эрсдэлийн хүрээнд

зохих шат дараалсан арга хэмжээг авч ажиллалаа. Энэ нь санхүүгийн хүндрэлд орсон 196 харилцагчийн 26,0 сая төгрөгийн зээлийн болон шимтгэлийн дүнг чөлөөлсөн байна. Мөн зээлийн эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх хяналтыг хиймэл оюун ухаанд тулгуурлан харилцагчийн скоринг тооцох ажил үргэлжлэн хийгдсээр байна. “ЛэндМН ББСБ” ХК нь “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам”,

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг шинэчлэн найруулж Гүйцэтгэх захирлын 2020/64 тоот тушаалаар баталлаа.

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага болох FATF нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-аас Монгол улсыг гаргах эсэх талаар газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 сарын 01-ны өдөр хийсэн билээ.

Тус төрийн албан ёсны уулзалтад FATF-ын шалгалтаар ирсэн биет төлөөлөгчидтэй ЛэндМН ББСБ ХК нь Банк бус санхүүгийн байгууллагын салбарыг, тэр дундаа Финтекийн үйл ажиллагаа эрхлэдэг нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг төлөөлж оролцлоо.

Уулзалтаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны чиглэлээр Банк бус санхүүгийн байгууллагын салбарт гарсан өөрчлөлт, хууль эрх зүйн хэрэгжилт, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт болон компанийн дотоод журам, түүний хэрэгжилтийн талаар амжилттай тайлагналаа.



## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2020 он I улирал	2020 он II улирал	2020 он III улирал
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	29.2%	41.1%	<b>46.3%</b>
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	29.2%	41.1%	<b>46.3%</b>
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	20%-иас доошгүй	28.3%	40.0%	<b>44.8%</b>
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	15.8%	38.1%	<b>25.5%</b>
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-8.3%	-0.7%	<b>-2.9%</b>
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	78.7%	60.1%	<b>53.4%</b>
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	25.0%	41.2%	<b>39.3%</b>



05

# Харилцагчийн үйлчилгээ

## Харилцагчийн үйлчилгээний төв

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 32 ажилтнуудтайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2020 оны III улирлын турш нийт 110,785 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний лавлагааг үзүүлж тэдгээрийн 99.81%-д амжилттай үйлчлэн асуудлыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.



**6 сек**

Хүлээлгийн  
түвшин

**110'785**

3-р улирлын  
нийт дуудлага

**99.81%**

Амжилттай  
үйлчилсэн



**17'801**

Сошиал сувгаар  
үйлчилсэн  
/Фэйсбүүк болон и-мэйл/



**2'411**

Үйлчилгээний заалаар  
үйлчилсэн

## 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй танилцууллаа

Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын Хөрөнгийн Бирж дээр 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдөр танилцууллаа. Тайланг Mongolian Stock Exchange - Монголын Хөрөнгийн Бирж болон LendMN фейсбүүк хуудсаар шууд дамжуулж олон нийтэд нээлттэй хэлбэрээр танилцууллаа.

Тайлант хугацаанд системийн шинэчлэлд анхаарч ажилласан бөгөөд дараах үр дүнд хүрсэнг онцоллоо. Үүнд:

- “ЛэндМН Бонд” нээлттэй өрийн хэрэгслийг амжилттай гаргаж, жилийн 17 хувийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээ.
- Системийн хөгжүүлэлт хийж, зээлийг хэсэгчлэн төлөх болон бонус оноогоор шимтгэлийн хэмжээг бууруулах боломжийг бүрдүүлээ.
- Цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар өсч, 2.8 тэрбум төгрөгт хүрсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) сайтаас авах боломжтой.



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.08.07

**06**

# Компанийн засаглал



## Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2020 оны III улиралд ээлжит 1, ээлжит бус 1 удаа хуралдаж нийт 7 тогтоол тус тус гаргалаа.

ТҮЗ-ийн хурлаас гарсан тогтоолуудын агуулгыг дурдвал:

- “Лэнд Хэтэвч” цахим төлбөр тооцооны үйлчилгээг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс “Супер Ап Хэтэвч” ХХК-д шилжүүлэв.
- Covid-19 вирусын цар тахлаас үүдэн эдийн засагт үүссэн нөхцөл байдалтай уялдуулан ТҮЗ-өөс 2020 оны төсөвт тодотгол хийж, төсвийг шинэчлэн батлав.
- 2020 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгож, 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулав.
- “Дижитал Молл” ХХК-тай дараа төлбөрт худалдан авалтын санхүүжилтийн “SupPAY” үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- “SuperUp” хэтэвчээр дамжуулан “ЛэндМН ББСБ” ХК-ийн үйлчилгээг хэрэглэж буй хэрэглэгчийн төлбөр тооцоог гүйцэтгэх, түүнтэй холбогдуулан “Супер Ап Хэтэвч” ХХК-тай төлбөр тооцооны үйлчилгээний гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- Эх үүсвэрийн 2020 оны төлөвлөгөөний дагуу Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татан төвлөрүүлэх зорилгоор “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.

Аудитын хороо 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

- Тайлан бүртгэлийн албаны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан;
- Өмнөх аудитын зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянасан тайлан;
- Дотоод хяналтын бодлогын агуулга, хамрах хүрээ;
- 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх аудитын байгууллага сонгох.

Эрсдэлийн удирдлагын хороо 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, хурлаар дараах асуудлыг хэлэлцлээ.

- Компанийн эрсдэлийн удирдлагын тайлан;
- Санхүүгийн эрсдэлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛУУДАЙ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН  
([HTTP://MSE.MN/MN](http://MSE.MN/MN)) ЦАХИМ ХУУДАСНААС ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ.**

### Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТҮЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг

Утас: 9901-8886

Имэйл: board@lend.mn



**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)